## Гарчиг

Бичмэл мэдээлэл


I. Төсвийн орлого
II. Төсвийн зарлага
III. Банк
IV. Бүртгэлтэй ажилгүйчүүд
V. Ажлын байрны зуучлал
VI. Нийгмийн халамж
VII. Нийгмийн даатгал
VIII. Эрүүл мэнд
IX. Хэрэглээний барааны үйлчилгээний үнэ, үнийн индекс
X. Хөдөө аж ахуй
XI. Аж үйлдвэр
XII. Гэмт хэрэг
XIII. Байгаль орчин
XIV. Гамшиг, осол, гал түймрийн мэдээ

# Хүснэгтэн мэдээлэл


I. Орон нутгийн төсвийн орлогын мэдээлэл
II. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт /Сумаар/
III. Орон нутгийн төсвийн зарлагын дүн
IV. Дундговь аймаг дахь банкны салбарын мэдээлэл
V. Аймгийн ажил хайгч иргэдийн мэдээлэл
VI. Ажлын байрны зуучлал
VII. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, тэтгэврийн санхүүжилт
VIII. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага
IX. Нийгмийн даатгал заавал даатгуулагчийн тоо, тэтгэврийн хэмжээ
X. Хүн амын ердийн хөдөлгөөн, хүүхдийн эндэгдэл
XI. Эрүүл мэндийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд
XII. Гол нэрийн бүтээгдэхүүний үнэ
XIII. Хэрэглээний үнийн индекс
XIV. ХАА-н бүтээгдэхүүний үнийн мэдээ
XV. Төл бойжилтын мэдээ
XVI. Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн
XVII. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт
XVIII. Нийгмийн халамжийн сангийн мэдээ
XIX. Гэмт хэргийн мэдээ
XX. Гэмт хэргийн мэдээ /Үргэлжлэл/
XXI. Гамшиг, осол, гал түймрийн  мэдээ

# Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал
# (2020 оны 4-р сарын байдлаар)

## I.Төсвийн орлого

Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2020 оны 4-р сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 73.2 хувьтай буюу 2 549.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 105.5 хувьтай буюу 633.3 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 3 210.1 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 78.0 хувьтай байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 33 839.7 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 94.0 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 5 414.2 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 9 763.7 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 609.3 сая төгрөг, хандив тусламжаас 73.0 сая төгрөг, төсвөөс санхүүжих 11 222.6 сая төгрөг, аймгаас авсан татаас 4 180.1 сая төгрөг, нийт 31 262.9 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

Орон нутгийн төсвийн орлогынхоо төлөвлөгөөг Дэрэн, Өндөршил, Гурвансайхан, Өлзийт, Хулд, Эрдэнэдалай сумд 1.5-34.9 хувиар буюу 0.7-44.5 сая төгрөгөөр тасалдуулсан бол бусад бүх сумд 2.0-21.8 хувиар буюу 0.9-37.2 сая төгрөгөөр төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн байна.

## II.Төсвийн зарлага

2020 оны 4 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зардлын дүн 18 676.5 сая төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 39.4 хувиар өссөн байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал 8 818.7 сая төгрөг болж нийт зардлын 47.2 хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд

төлөх шимтгэл өмнөх оноос 18.3 хувиар өсч 1 099.7 сая төгрөг болсон байна. Тухайн сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулбал хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас 56.3 хувь, хөрөнгийн зардал 13.9 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 10.5 хувь, хангамжийн бараа материалын зардал 9.3 хувиар тус тус өссөн бол байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, норматив зардал, томилолтын зардал, эд хогшил урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардал, бусад урсгал шилжүүлэг 3.2-63.6 хувиар буурсан байна.

## III.Банк

Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар өсч, 113 148.6 сая төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 1 486.6 сая төгрөг, чанаргүй зээл 1 289.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 100.9 хувиар, чанаргүй зээл 18.8 хувиар тус тус өссөн байна. Нийт зээлийн үлдэгдлийн 2.4 хувийг анхаарал хандуулах ба чанаргүй зээл эзэлж байна. Нийт хадгаламжийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар өсч, 66 621.7 сая төгрөг болсон ба мөн нийт харилцахын үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 25.4 хувиар буурч 12 048.9 сая төгрөг болов.

## IV.Бүртгэлтэй ажилгүйчүүд

2020 оны 4 сарын байдлаар аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй, ажил хайж байгаа 362 хүн бүртгэгдсэн нь өмнөх сартай харьцуулахад 19.1 хувиар буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 43.9 хувь буюу 159 хүн нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 112 ажил хайгч иргэн ногдож байхад Цагаандэлгэр 318, Говь-Угтаал 262, Өндөршил 234, Хулд 247, Луус 158, Гурвансайхан 179, Дэлгэрхангай 152, Сайхан-Овоо 206, Дэрэн 136, Баянжаргалан 117 байгаа нь аймгийн дунджаас дээгүүр байна.

## V. Ажлын байрны зуучлал

ХХҮГазрын 2020 оны 4 сарын мэдээгээр нийт 140 хүн ажлын байранд зуучлагдсан нь өмнөх оны мөн үеэс 2 хүнээр өссөн байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд ХАА, ан агнуур, ойн аж ахуйн салбарт 1.4 хувь, боловсруулах үйлдвэрт 0.7 хувь, цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт 0.7 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт 10.7 хувь, боловсролын салбарт 8.6 хувь, үйлчилгээний бусад салбарт 48.6 хувь, хүний эрүүл мэнд нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт 3.6 хувь, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагааны салбарт 21.4 хувь, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт 0.7 хувь, урлаг, үзвэр, тоглоом наадмын салбарт 2.1 хувь, санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбарт 0.7 хувь, бөөний ба жижиглэнгийн худалдааны салбарт 0.7 хувь нь зуучлагдсан байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийн 91 нь буюу 65.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

## VI. Нийгмийн халамж

2020 оны эхний 4 сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас 15 760 хүнд 2 235.4 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, халамжийг олгосон байна. Нийт тэтгэвэр тэтгэмж авагчдын 20.5 % буюу 3 239 нь 0-3 насны хүүхдээ асарч буй эхчүүд болон олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эх, жирэмсэн эмэгтэйчүүдэд 185.5 сая төгрөг, нийгмийн халамжийн тэтгэмжийг 1671 иргэнд 484.3 сая төгрөг, халамжийн тэтгэврийг 770 иргэнд 626.2 сая төгрөгийг бусад төрлийн тусламж үйлчилгээнд 163 иргэнийг хамруулан 37.3 сая, 4 434 эхэд алдарт эхийн одонгийн мөнгөн тусламж 595.7 сая, 2 493 өндөр настанд насны хишигт 223.5 сая төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 2 990 иргэнд 89.9 сая төгрөгийг зарцуулжээ..

## VII. Нийгмийн даатгал

Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны 4 сарын байдлаар 13 271.7 сая төгрөг, зарлага 11 148.6

сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого сая төгрөгөөр, зарлага 1 305 .3 сая төгрөг буюу 10.9 хувиар өслөө.

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд 2020 оны 4 сарын байдлаар 8669 хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 1944 хүн буюу 22.5 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 3762 хүн буюу 43.3 хувь нь төсөвт байгууллагаас, 2963 хүн буюу 34.2 хувь нь сайн дураар шимтгэл төлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аж ахуй нэгж байгууллага даатгуулагч, төсөвт байгууллагын даатгуулагч өссөн сайн дурын даатгуулагч буурсан байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2020 оны 4 сарын байдлаар 7 429.0 сая төг болж, үүний 82.6 хувийг өндөр настны, 11.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.2 хувийг тэжээгчээ алдсаны, 1.8 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 7429 хүн байна. Нийт тэтгэвэр авагчдын 83.1 хувь буюу 6172 хүн өндөр насны, 11.8 хувь буюу 876 хүн тахир дутуугийн, 3.2 хувь буюу 239 хүн тэжээгчээ алдсаны, 1.8 хувь буюу 139 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 847, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 25, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагч 63 хүн байна. Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо 10477 байгаагийн 73.3 хувь буюу 7689 төр хариуцах иргэд, 17.3 хувь буюу 1813 малчид, 2.6 хувь буюу 278 оюутан суралцагсад, 6.6 хувь нь буюу 697 аж ахуй нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн байна.

2020 оны 4 сарын байдлаар аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 4 036.2 сая төгрөг болж төлөвлөгөөгөө 18.1 хувиар буюу 894.8 сая төгрөгөөр дутсан байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө бүх суманд буурсан байна.

## VIII. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2020 оны 4-р сарын байдлаар 299 эх төрсөн ба нийт 301 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 1 тохиолдлоор өссөн байна. Төрсөн эхчүүдийн 89.9

хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ сарын байдлаар 0-5 насны хүүхдийн 1 эндэгдэл гарсан байна. Нас баралтын 77 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 8 тохиолдлоор буурчээ. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт 18 буюу 23.4 хувийг эзэлж байна.

Тухайн сарын байдлаар стационарит шинээр 3788 эмчлүүлэгч хэвтэж, 3796 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 26827 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.1 байна. Нийт 63851 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 26.9%, өвчний учир амбулаторийн үзлэг 51.5%, идэвхтэй хяналт 14.7%, гэрийн үзлэг 4.7%- ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 32.6 хувь нь эрэгтэй, 67.4 хувь нь эмэгтэй хүн байна. Халдварт өвчний 118 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 25.3% болж өмнөх оны мөн үеэс 24 тохиолдол буюу 5.2 пунктээр буурсан байна

## IX. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ, үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхийнхийг биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2020 оны 4-р сарын байдлаар хэрэглээний үнийн индекс 2019 оны 4-р сартай харьцуулахад 6.5 хувиар өсжээ.

Хэрэглээний үнийн индекс 6.5 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 10.3 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 2.0 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлэг 9.5 хувь өссөн, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 8.0 хувиар өссөн, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 5.5 хувь, эм тариа эмчилгээний бүлэг 2.9 хувиар өссөн, тээврийн бүлэг 2.9 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

2020 оны 4 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин, дизель түлшний үнийг орууллаа.

ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /7 хоногоор/

| № | Барааны нэр, төрөл | IV/01 | IV/08 | IV/15 | IV/22 | IV/29 |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Гурил, 1-р зэрэг, кг | 1450 | 1450 | 1450 | 1450 | 1560 |
| 2 | Хонины мах, кг | 8600 | 8600 | 8700 | 8900 | 8700 |
| 3 | Үхрийн мах, кг | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4 | Ямааны ястай мах, кг | 7600 | 7600 | 7000 | 7200 | 7200 |
| 5 | Элсэн чихэр, кг | 2000 | 2000 | 2000 | 2000 | 2000 |
| 6 | Цагаан будаа, кг | 2600 | 2600 | 2600 | 2600 | 2600 |
| 7 | Шингэн сүү, л | 3500 | 3500 | 3500 | 3500 | 3500 |
| 8 | Ноолуурын үнэ 1 кг | 65000 | 50000 | 45000 | 55000 | 45000 |
| 9 | Бензин А-80, 1литр | 1750 | 1750 | 1450 | 1450 | 1490 |
| 10 | Бензин А-92, 1литр | 1860 | 1860 | 1560 | 1560 | 1580 |
| 11 | Дизель түлш 1 литр | 2490 | 2490 | 2190 | 2190 | 2240 |

## X.Хөдөө аж ахуй



Аймгийн хэмжээгээр энэ оны эхний 4 сарын байдлаар 852. 0 мянган хээлтэгч мал төллөж, гарсан төл 99.3 хувь буюу 846.1 мянган төл бойжиж байна.

Аймгийн хэмжээнд энэ оны 5 сарын 1-ний байдлаар 5210 толгой мал хорогдоод байна.

## XI. Аж үйлдвэр



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2020 оны 4 сарын байдлаар 3 292.7 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 14.5 хувиар буурсан байна.

## XII.Гэмт хэрэг



2020 оны эхний 04 дүгээр сард Улсын хэмжээнд 10130 гэмт хэрэг бүртгэгдсэний 99 буюу 0.9 хувийг, Орон нутагт нийт 3452 гэмт хэрэг бүртгэгдсэний 2.8 хувийг Дундговь аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг эзэлж, өмнөх оны мөн үеэс 11 хэргээр буюу 12.5 хувиар гэмт хэргийн гаралт өссөн байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 234.8 сая төгрөгийн хохирлын 98.5 сая төгрөгийн хохирлыг мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлж, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт 42 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 20.3 пунктээр өссөн. Тайлангийн хугацаанд 30 сая төгрөгийн эд хөрөнгө битүүмжилсэн байна. Гэмт хэргийн улмаас 96 иргэн хохирч, 4 хүн нас барж, 38 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүний тоо 7.8 хувиар, гэмтсэн хүн 72.7 хувь, нас барсан хүний тоо 33.3 хувиар тус тус өссөн байна.

Гэмт хэргийн илрүүлэлт Улсын хэмжээнд 35.9 хувьтай, Дундговь аймагт 45.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс Улсын хэмжээнд 10.9 хувиар өссөн бол Дундговь аймагт 7.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт гэмт хэрэгт холбогдогчийн 4 буюу 8.2 хувь нь эмэгтэй хүн, 18 хүртэлх насны холбогдогч байхгүй, 12 буюу 24.5 хувийг хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 11-ээр өсч, эмэгтэй холбогдогчийн тоо 50 хувь, 18 хүртэлх насны холбогдогчийн тоо 100 хувиар тус тус буурсан байна.

**<u>Зөрчлийн нөхцөл байдлын талаар:</u>**

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 04 дугаар сард 6228 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үеэс 51 зөрчлөөр буюу 0.8 хувиар, 6236 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 55 зөрчлөөр буюу 0.9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зөрчил гаргасан 6122 иргэнийг 184.9 сая төгрөгөөр торгон, 53 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж, 29 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.

Нийт 135 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 116 хүнээр буюу 53.8 хувиар буурч, нийт эрүүлжүүлэгдсэн хүний 27.4 хувь нь гудамж талбайгаас, 62.2 хувь нь гэр, орон сууцнаас, 4.4 хувь нь байгууллага, аж ахуйн нэгжээс болон зочид буудлаас, 0.7 хувь нь үзвэр үйлчилгээний газраас, 5.2 хувь нь бусад газраас эрүүлжүүлэгдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэгч 13 иргэн зөрчил үйлдсэнээс 11 нь нөхөр, 2 нь бусад этгээд байна. Зөрчлийн улмаас 10 иргэн хохирсон, үүнээс 9 буюу 90 хувь нь эмэгтэйчүүд, 1 буюу 10 хувь нь насанд хүрээгүй хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон байна.

## XIII. Байгаль орчин

### ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Энэ сард агаарын дундаж температур ОЖД–аас нийт нутгаар дулаан хур тунадас нийт нутгаар ОЖД–аас бага байна.

Агаарын температур эхний арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхэн үеэр өмнөх үеэсээ хүйтэрнэ, харин хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн ихэнх хугацаанд ихэнх нутгаар дулаарна.

Нэгдүгээр арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн эхэн үеэр зарим газраар хур тунадас орох төлөвтэй.

Салхи нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхэн ба дунд үе, гуравдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр ихэнх нутгаар 14-16 м/с хүртэл ширүүсч шороон шуурга шуурах төлөвтэй байна.

## XIV. Гамшиг осол, гал түймрийн мэдээ

Аймгийн Онцгой байдлын газраас ирсэн мэдээгээр 2020 оны эхний 4 сарын байдлаар нийт ирсэн дуудлага өмнөх оны мөн үеэс 4-өөр буюу 44.4 хувиар өссөн бөгөөд эрэн хайх үйл ажиллагаа 50 хувиар буурсан байна. Мал амьтны гоц халдвар 4-өөр буюу 4 дахин өссөн, гал түймэр 33.3 хувиар буурсан бол орон нутгийн дуудлага 2-оор буюу 3 дахин өссөн байна.

# I.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН МЭДЭЭ, мянган төгрөгөөр

2020.05.11

| Үзүүлэлт | мөр | 2019 IV | 2020 IV | | | 20/19 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төл | гүйц | хувь | хувь |
| Нийт орлого /тусламжийн дүн/ | 1 | 15206041.7 | 35995963.4 | 33839728.6 | 94.0 | 222.5 |
| А.УРСГАЛ ОРЛОГО | 2 | 2368496.5 | 3484435.4 | 2549915.0 | 73.2 | 107.7 |
| I.ТАТВАРЫН ОРЛОГО | 3 | 1432530.9 | 1373039.0 | 1556684.3 | 113.4 | 108.7 |
| 1.1 Хүн амын орлогын албан татвар | 4 | 1115143.1 | 1003710.0 | 1348117.6 | 134.3 | 120.9 |
| 1.1 Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар | 5 | 1021365.3 | 1020000.0 | 1216770.8 | 119.3 | 119.1 |
| Хувь хүний орлогын албан татварын буцаалт | 6 | 0.0 | -112000.0 | 0.0 | - | - |
| 1.2 үйл ажиллагааны орлого | 7 | 58239.7 | 80710.0 | 66647.3 | 82.6 | 114.4 |
| 1.3 Хөрөнгө борлуулсаны | 8 | 7590.6 | 15000.0 | 61318.9 | - | 807.8 |
| 1.5 Бусад татвар | 9 | 27947.5 | 0.0 | 3380.6 | - | 12.1 |
| 2.Хөрөнгийн татвар/ҮХХболон буу/ | 10 | 29132.7 | 59660.0 | 24523.9 | 41.1 | 84.2 |
| 3. Авто тээврийн хэрэгслийн | 11 | 150297.5 | 148600.0 | 37069.7 | 0.0 | 24.7 |
| 4. Бусад татвар | 12 | 137957.6 | 161069.0 | 146973.1 | 91.2 | 106.5 |
| 4.1 Улсын тэмдэгтийн | 13 | 39550.1 | 52860.0 | 48965.7 | 92.6 | 123.8 |
| 4.2 Ашигт малтмал нөөцийн | 14 | 1745.6 | 1200 | 1566.7 | - | 89.8 |
| 4.3 Газрын төлбөр | 15 | 35628.2 | 62815.0 | 40052.1 | 63.8 | 112.4 |
| 4.5 Хог хаягдалын үйлчилгээний | 16 | 3198.7 | 41800.0 | 31673.2 | 75.8 | 990.2 |
| 4.6 Усны төлбөр | 17 | 17445.3 | 2394.0 | 17757.3 | - | 101.8 |
| 4.6.Бусад | 19 | 40389.7 | 0.0 | 6958.1 | - | 17.2 |
| II.ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 20 | 935965.6 | 2111396.4 | 993230.7 | 47.0 | 101.6 |
| 2.1 Төсөвт байгууллагын өөрийн орлого | 21 | 553771.4 | 1772726.4 | 554648.7 | 31.3 | 100.2 |
| 2.2 Бусад нэр заагдаагүй | 22 | 382194.2 | 338670.0 | 438582.0 | 129.5 | 114.8 |
| Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО | 23 | 47684.5 | 31000.0 | 26922.8 | 86.8 | 56.5 |
| В.ТУСЛАМЖИЙН ОРЛОГО | 24 | 12789860.7 | 32480528.0 | 31262890.8 | 96.3 | 244.4 |
| 1.Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг | 25 | 4706689.1 | 6294485.3 | 5414245.7 | 86.0 | 115.0 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 26 | 7720679.6 | 8868962.7 | 9763688.6 | 110.1 | 126.5 |
| Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс санхүүжих | 27 | 337814.0 | 1436148.0 | 609265.7 | 42.4 | 180.4 |
| Хандив тусламж | 28 | 24678.0 | 115882.8 | 72999.3 | 63.0 | - |
| Төсвөөс санхүүжих | 29 | 0.0 | 11435770.7 | 11222600.4 | 98.1 | - |
| Аймаг нийслэлээс авсан татаас | 30 | 0.0 | 4329278.5 | 4180091.1 | 96.6 | - |
| Орон нутгийн төсвийн орлого /тусламжийн орлого ороогүй / | 31 | 2416181.0 | 3515435.4 | 2576837.8 | 73.3 | 106.6 |
| Улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлого | 32 | 680910.0 | 600470.0 | 633279.9 | 105.5 | 93.0 |
| Аймгийн нийт орлого | 33 | 3097091.0 | 4115905.4 | 3210117.7 | 78.0 | 103.6 |

# II.ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

2020.05.11

| Сумд | 2020 I-IV | | | 2020 IV сар | | |
|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө | гүйцэтгэл | хувь | төлөвлөгөө | гүйцэтгэл | хувь |
| Дэлгэрцогт | 32160.0 | 39174.1 | 121.8 | 8860.0 | 9489.6 | 107.1 |
| Дэрэн | 44780.0 | 38265.2 | 85.5 | 19710.0 | 10536.1 | 53.5 |
| Говь-Угтаал | 214900.0 | 244919.7 | 114.0 | 68630.0 | 40002.1 | 58.3 |
| Цагаандэлгэр | 26270.0 | 27149.5 | 103.3 | 10750.0 | 7490.6 | 69.7 |
| Баянжаргалан | 57745.0 | 64806.9 | 112.2 | 27430.0 | 9356.2 | 34.1 |
| Өндөршил | 45660.0 | 44985.9 | 98.5 | 19300.0 | 11791.7 | 61.1 |
| Гурвансайхан | 137390.0 | 92887.5 | 67.6 | 67640.0 | 35847.9 | 53.0 |
| Өлзийт | 67525.0 | 43980.7 | 65.1 | 28260.0 | 11266.5 | 39.9 |
| Хулд | 80830.0 | 59915.3 | 74.1 | 30820.0 | 22889.1 | 74.3 |
| Луус | 47580.0 | 48508.5 | 102.0 | 20520.0 | 12323.7 | 60.1 |
| Дэлгэрхангай | 68680.0 | 74874.6 | 109.0 | 22670.0 | 14152.6 | 62.4 |
| Сайхан-Овоо | 40720.0 | 45800.5 | 112.5 | 15550.0 | 14209.7 | 91.4 |
| Эрдэнэдалай | 123420.0 | 80582.5 | 65.3 | 51400.0 | 19993.6 | 38.9 |
| Сайнцагаан | 220927.0 | 258134.5 | 116.8 | 79740.0 | 67038.4 | 84.1 |
| Адаацаг | 46375.0 | 53670.6 | 115.7 | 15735.0 | 11865.9 | 75.4 |
| Дундговь | 881280.0 | 1446397.1 | 164.1 | 110340.0 | 405170.9 | 367.2 |
| Дүн | 2136242.0 | 2664053.1 | 124.7 | 597355.0 | 703424.6 | 117.8 |

## III.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ДҮН, сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

2020.05.11

| Зарлагын төрөл | 2019 IV | 2020 IV | | | 2020 IV /2019 IV |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | |
| Орон нутгийн байгууллагын зарлага | 13394236.4 | 27095241.1 | 18676510.1 | 68.9 | 139.4 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 7426898.6 | 10006414.4 | 8818662.8 | 88.1 | 118.7 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 929769.1 | 1342064.5 | 1099657.7 | 88.1 | 118.3 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2195062.8 | 2604330.5 | 2124492.1 | 81.9 | 96.8 |
| Хангамж бараа материалын зардал | 215289.2 | 362750.8 | 235258.3 | 64.9 | 109.3 |
| Норматив зардал | 393858.5 | 194577.0 | 146143.4 | 75.1 | 37.1 |
| Эд хогшил урсгал засварын зардал | 98063.8 | 143118.1 | 83602.0 | 58.4 | 85.3 |
| Томилолтын зардал | 74797.2 | 39830.4 | 38782.5 | 97.4 | 51.9 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж | 236352.9 | 409115.4 | 261285.2 | 63.9 | 110.5 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 866153.3 | 1858489.5 | 420375.8 | 22.6 | 48.5 |
| Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 80237.7 | 125400.0 | 125400.0 | 100.0 | - |
| Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0.0 | 4350885.6 | 4180091.1 | - | - |
| Бусад урсгал шилжүүлэг | 498870.9 | 260991.2 | 181705.3 | 69.6 | 36.4 |
| Хөрөнгийн зардал | 378882.4 | 2979144.6 | 431511.3 | 62.2 | - |
| Эргэж төлөгдөх зээл | 0 | 2418129.1 | 529542.6 | 21.9 | - |

# IV. ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ БАНКНЫ САЛБАРЫН МЭДЭЭ

2020.05.11 (Сая.төгрөг, тоогоор)

| Үзүүлэлт | | | Үлдэгдэл | | 2019/2020 хувь |
|---|---|---|---|---|---|
| | | | 2019-IV | 2020-IV | |
| **Зээл** | **Нийт зээлийн үлдэгдэл** | | 111645.4 | 113,148.6 | 101.3 |
| | Үүнээс: | Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл | 739.8 | 1,486.6 | 200.9 |
| | | Чанаргүй зээлийн үлдэгдэл | 1085.9 | 1,289.6 | 118.8 |
| **Татан төвлөрүүлсэн хөрөнгө** | **Нийт харилцахын үлдэгдэл** | | 16158.6 | 12,048.9 | 74.6 |
| | Үүнээс: | Иргэдийн харилцахын үлдэгдэл | - | 6,526.0 | - |
| | **Нийт хадгаламжийн үлдэгдэл** | | 61412.7 | 66,621.7 | 108.5 |
| | Үүнээс: | Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл | - | 66,587.0 | - |
| | | Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл | 17705.6 | 12,593.6 | 71.1 |
| | | Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл | 43707.1 | 54,028.0 | 123.6 |
| **Тоон мэдээлэл** | **Нийт банкны салбар, нэгжийн тоо** | | - | 34 | - |
| | **Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо** | | - | 170 | - |
| | **Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор)** | | - | 21372 | - |
| | **Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)** | | - | 84671 | - |
| | **Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)** | | - | 33451 | - |
| | **Нийт АТМ-ны тоо** | | - | 19 | - |
| | **Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо** | | - | 40713 | - |

# V. АЙМГИЙН АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН МЭДЭЭ

2020.05.11

| Сум | Оны эхний хөдөлмөрийн насны хүн ам | Тайлант сарын эхэнд байсан ажилгүйчүүд | Тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүд | Үүнээс эмэгтэй | Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүйчүүд |
|---|---|---|---|---|---|
| Дэлгэрцогт | 1178 | 2 | 10 | 2 | 85 |
| Дэрэн | 1474 | 19 | 20 | 6 | 136 |
| Говь-Угтаал | 1106 | 51 | 29 | 16 | 262 |
| Цагаандэлгэр | 723 | 31 | 23 | 9 | 318 |
| Баянжаргалан | 858 | 10 | 10 | 3 | 117 |
| Өндөршил | 1027 | 23 | 24 | 8 | 234 |
| Гурвансайхан | 1560 | 28 | 28 | 7 | 179 |
| Өлзийт | 1712 | 1 | 2 | 1 | 12 |
| Хулд | 1697 | 36 | 42 | 23 | 247 |
| Луус | 1331 | 21 | 21 | 7 | 158 |
| Дэлгэрхангай | 1581 | 23 | 24 | 11 | 152 |
| Сайхан-Овоо | 1508 | 31 | 31 | 18 | 206 |
| Эрдэнэдалай | 3954 | 95 | 2 | 0 | 5 |
| Сайнцагаан | 10649 | 59 | 78 | 39 | 73 |
| Адаацаг | 1958 | 17 | 18 | 9 | 92 |
| Дүн | 32316 | 447 | 362 | 159 | 112 |

# VI. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, 2020 оны 04 сарын байдлаар

2020.05.11

| Эдийн засгийн салбарын ангилал | Ажилд зуучилсан иргэд | үүнээс: эмэгтэй | Эдийн засгийн салбарын эзлэх хувь |
|---|---|---|---|
| ХАА, ан агнуур, ойн аж ахуй | 2.0 | 1.0 | 1.4 |
| Уул уурхай олборлох үйлдвэр | 0.0 | 0.0 | 0.0 |
| Боловсруулах аж үйлдвэр | 1.0 | 0.0 | 0.7 |
| Цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт | 1.0 | 0.0 | 0.7 |
| Усан хангамж, бохир ус, зайлуулах систем, хог | 0.0 | 0.0 | 0.0 |
| Барилга | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бөөний ба жижиглэн худалдаа | 1.0 | 1.0 | 0.7 |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 1.0 | 1.0 | 0.7 |
| Зочид буудал, зоогийн газар | 0.0 | 0.0 | 0.0 |
| Мэдээлэл холбоо | 0.0 | 0.0 | 0.0 |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 1.0 | 1.0 | 0.7 |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 15.0 | 9.0 | 10.7 |
| Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа | 30.0 | 19.0 | 21.4 |
| Боловсрол | 12.0 | 9.0 | 8.6 |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа | 5.0 | 2.0 | 3.6 |
| Урлаг, үзвэр, тоглоом наадам | 3.0 | 2.0 | 2.1 |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 68.0 | 46.0 | 48.6 |
| Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бүгд | 140.0 | 91.0 | 100.0 |

# VII.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, ТЭТГЭВЭРИЙН САНХҮҮЖИЛТ

2020.05.11 мян.төг

| Сумд | Н.Д.Шимтгэлийн орлого | | | Тэтгэвэрийн санхүүжилт | | |
|---|---|---|---|---|---|---|
| | төл | гүйц | хувь | олгох | олгосон | хувь |
| Дэлгэрцогт | 117500.9 | 94341.7 | 80.3 | 453078.8 | 453078.8 | 100.0 |
| Дэрэн | 114454.0 | 100487.1 | 87.8 | 493601.7 | 493601.7 | 100.0 |
| Говь-Угтаал | 148471.5 | 117177.3 | 78.9 | 400039.8 | 400039.8 | 100.0 |
| Цагаандэлгэр | 81519.4 | 71239.2 | 87.4 | 223134.1 | 223134.1 | 100.0 |
| Баянжаргалан | 151626.7 | 100245.7 | 66.1 | 241266.9 | 241266.9 | 100.0 |
| Өндөршил | 123769.6 | 100025.1 | 80.8 | 317431.7 | 317431.7 | 100.0 |
| Гурвансайхан | 136940.7 | 121695.5 | 88.9 | 432239.1 | 432239.1 | 100.0 |
| Өлзийт | 148221.4 | 131573.6 | 88.8 | 554400.3 | 554400.3 | 100.0 |
| Хулд | 170136.6 | 139761.3 | 82.1 | 534755.6 | 534755.6 | 100.0 |
| Луус | 141444.5 | 110742.0 | 78.3 | 446402.7 | 446402.7 | 100.0 |
| Дэлгэрхангай | 161834.8 | 138426.0 | 85.5 | 517000.9 | 517000.9 | 100.0 |
| Сайхан-Овоо | 115592.5 | 98242.5 | 85.0 | 410386.6 | 410386.6 | 100.0 |
| Эрдэнэдалай | 334301.4 | 264283.4 | 79.1 | 1321228.3 | 1321228.3 | 100.0 |
| Адаацаг | 150118.3 | 116318.0 | 77.5 | 571532.9 | 571532.9 | 100.0 |
| Сайнцагаан | 2835044.4 | 2331633.4 | 82.2 | 4121934.6 | 4121934.6 | 100.0 |
| Дүн | 4930976.7 | 4036191.8 | 81.9 | 11038434.0 | 11038434.0 | 100.0 |

# VIII. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА /сая.төг/

2020.05.11

| | 2019 оны IV сар | 2020 оны IV сар | | | 2020 IV / 2019 IV хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | |
| Нийгмийн даатгалын сангийн орлого | 11966.4 | 4268.9 | 13271.7 | 310.9 | 110.9 |
| Үүнээс | | | | | |
| Тэтгэврийн даатгалын сангийн | 10331.1 | 4259.2 | 3437.4 | 80.7 | 33.3 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 518.1 | 355.2 | 547.8 | 154.2 | 105.7 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн | 782.2 | 0.0 | 765.7 | 0.0 | 97.9 |
| ҮОМШӨ*-ний даатгалын сангийн | 239.3 | 250.3 | 232.5 | 92.9 | 97.2 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 95.7 | 56.4 | 162.5 | 288.1 | 169.8 |
| Нийгмийн даатгалын сангийн орлого | 8164.8 | 11058.6 | 12772.6 | 12793.2 | 100.2 |
| Үүнээс | | | | | |
| Тэтгэврийн даатгалын сангийн | 9573.9 | 11980.6 | 11148.6 | 93.1 | 116.4 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 383.4 | 577.2 | 546.9 | 94.8 | 142.6 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн | 780.1 | 0.0 | 762.7 | 0.0 | 97.8 |
| ҮОМШӨ*-ний даатгалын сангийн | 219.6 | 54.4 | 222.5 | 409.0 | 101.3 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 101.6 | 160.4 | 112.5 | 70.1 | 110.7 |

Тайлбар: *Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал

## IX.НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧИЙН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ

2020.05.11

| Үзүүлэлтүүд | 2018 оны IV сар | 2019 оны IV сар | 2020 оны IV сар | 2020 IV / 2019 IV хувь |
|---|---|---|---|---|
| Заавал даатгуулагчийн тоо | 8976 | 9269 | 8669 | 93.5 |
| Үүнээс: | | | | |
| Аж ахуй нэгж байгууллага | 1858 | 1841 | 1944 | 105.6 |
